

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДАВ

2011 оны 7 дугаар сарын 1-ны өдөр Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл хуралдлаа. Хуралд Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч Б.Жавхлан, Сангийн дэд сайд Д.Ганхуяг, Сангийн яамны Санхүү эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Батбаяр, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун, Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Д.Болдбаатар, Валют, эдийн засгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал Ж.Батаа, Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал С.Болд нар оролцов.

Уг хуралдаанаар зээлийн хүүг бууруулах эдийн засгийн зохистой орчныг бүрдүүлэх хөтөлбөрийг батлуулах тухай, хөрөнгийн орж ирэх их хэмжээний урсгал, Төгрөгийн чангаралтын үед бүтээн байгуулалт, томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох ажлын хэсгийн ажлын явц, хадгаламжийн даатгалын хуулийн эцсийн хувилбар, ажлын хэсгийн тайлангын танилцуулга болон дэлхийн эдийн засаг, санхүүгийн байдал Монгол Улсад нөлөөлж болох боломжуудын талаар хэлэлцлээ.

Зээлийн хүүг бууруулах ажлын хэсгийн ажлын тайлантай танилцсан ба хоёр долоо хоногийн дараа Засгийн газрын хурлаар танилцуулж гарын үсэг зурахаар тогтов. Мөн зээлийн хүүг бууруулах ажлын хэсгийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан ахалж, төлөвлөгөө, удирдамжийг шинэчлэн боловсруулахаар тогтов.

Орж ирэх хөрөнгийн их хэмжээний урсгал, төгрөгийн чангаралтын үед бүтээн байгуулалт, томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох ажлын хэсгийг Сангийн яамны дэд сайд Д.Ганхуяг ахалж, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун орлож, төлөвлөгөө, удирдамжийг шинэчлэн томоохон хэмжээний бодлогын бичиг баримт 9 дүгээр сар гэхэд боловсруулахаар тогтов.

Хадгаламжийн даатгалын хуулийн эцсийн хувилбар, ажлын хэсгийн тайланг танилцуулсан ба хуулийн төсөл эцэслэн дууссан тул холбогдох яамдаас санал авч, ирэх чуулганаар УИХ-д өргөн барьж батлуулахаар тогтсон.

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн байдал Монгол Улсад нөлөөлж болох боломжуудын талаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах Хороо, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо саналаа нэмж нэгдсэн дүгнэлт байдлаар УИХ, ЗГ-т Монголбанкны Ерөнхийлөгч хариуцан танилцуулах. Гадаад, дотоод эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан эрсдэлийн менежментийг бодлого гаргаж шийдвэр гаргагч нарт мэдээлэл өгч байхаар тогтов.